



/БОНХЯ-ны 2014-03-17-ны А-86 тушаалаар хүчингүй болсон/

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ/ Усны мэдээллийн сан болон улсын усны кадастрыг бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам / 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хот Дугаар 180 Монгол Улсын Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь: 1. “Усны мэдээллийн сан болон улсын усны кадастрыг бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам”-ыг хавсралтаар баталсугай. 2. Энэхүү журмыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Усны хэрэг эрхлэх газар /Ц.Бадрах/, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Ц.Банзрагч/ нарт үүрэг болгосугай.

САЙД

И.ЭРДЭНЭБААТАР
өдрийн 2605 дугаарт бүртгэгдсэн

Улсын бүртгэлийн 2006 оны 6 дугаар сарын 19-ний